



ДУАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР



БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ
САН

Байгаль орчныг хамгаалах сангийн зарцуулалтын байдалд хийсэн
нийцлийн аудитын тайлан

ҮАГ-НАГ/2016/03-НА/



Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг бодитой төлөвлөн, зарцуулалтыг олон
нийтэд мэдээлэх шаардлагатай байна.

Мандалговь
2016 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	3
Дундговь аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Ерөнхий мэдээлэл	4-5 6
Тэргүүлэх аудитор Т.ОЮУНЧИМЭГ	БҮЛЭГ 1. Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчин бүрдсэн боловч журмын зарим заалт бодит байдалтай нийцэхгүй байна. 1.1. Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.	7
Аудитын менежер Х.НАРАНЦАЦРАЛ	1.2. Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй журмын зарим заалт бодит байдалтай нийцэхгүй байна. БҮЛЭГ 2. Сангийн хөрөнгийг төлөвлөх, хуульд заасны дагуу бүрэн бүрдүүлэх ажил хангалтгүй байна.	7
Ахлах шинжээч Д.ИХБАЯР	2.1. Сумдын Засаг дарга нар сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөөгүй байна.	8-10
Аудитор Х.ГАРАМ	2.2. Сангийн орлогын төлөвлөгөө батлуулаагүйгээс орлогыг хууль, журамд заасны дагуу төрөл тус бүрээр бүрдүүлэх ажилд санаачлагагүй хандсан байна.	10-14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	БҮЛЭГ 3. Сангийн хөрөнгийг зөвхөн сумын Засаг даргын шийдвэрээр хяналтгүй зарцуулж байна. 3.1 Зарим сумдын Засаг дарга нар сангийн хөрөнгийг урсгалаар, зориулалтын бус зардалд зарцуулж байна.	15-18
	3.2. Гурвансайхан сум сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажил үйлчилгээний худалдан авах ажиллагаанд ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөөгүй байна.	18
	БҮЛЭГ 4. Дотоод хяналтын мөрөөр авч хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, байгаль хамгаалах сангийн зарцуулалтыг олон нийтэд мэдээлэх шаардлагатай байна. 4.1 Сангийн үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна.	19
	4.2. Дотоод хяналтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг сайтар зохион байгуулаагүй байна.	19-20
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот	4.3. Байгаль хамгаалах сангийн мэдээ тайланг олон нийтэд мэдээлээгүй, шилэн дансны нэгдсэн цахим сайтад тусгай нэр хаяг нээгээгүй байна.	20
	Дүгнэлт	21
	Зөвлөмж	22-23
	Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал	24
	Аудитын газрын тайлбар	25
2016 оны 10 дугаар сар	Аудитын тайланг баталгаажуулсан тушаал	26-28
	Тайлангийн хавсралтууд	29-35

ТОВЧИЛСОН ҮГС

ЗГ	Засгийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон Улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний Аудитын газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОУБ	Байгаль орчны улсын байцаагч
НББ	Нягтлан бодох бүртгэл
НАТО	Нөөц ашигласны төлбөрийн орлого
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-ын харьяа Дундговь аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр Дундговь аймагт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Хууль эрх зүйн зохицуулалт нь үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх,
- ❖ Сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх,
- ❖ Сангийн хөрөнгийг хууль, журамд заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх,
- ❖ Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.

Байгаль хамгаалах сангийн зарцуулалтад хийх нийцлийн аудитын ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөөний асуудлын шинжилгээнд аймаг орон нутгийн онцлогтой холбоотой нэгтгэн бичих шаардлагатай дараах бүлгүүдийн заалтуудыг нэгтгэн тайланг бичлээ. Үүнд:

- 1 дүгээр бүлгийн 1.3 дугаар асуудлыг 1.2 дугаар асуудалтай,
- 3 дугаар бүлгийн 3.3, 3.4 дүгээр асуудлыг 3.2 дугаар асуудалтай нэгтгэлээ.

Аудитын хамарсан хүрээ: Батлагдсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аймаг, сумын Засаг дарга, аймгийн БОАЖГ, 15 сумын байгаль орчны улсын байцаагч, байгаль орчныг хамгаалах сангийн баримт материалыг хамруулж, 2015, 2016 онд байгаль орчныг хамгаалах санд хуульд заасны дагуу төвлөрүүлсэн орлого болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаарх ажлын тайлан, анхан шатны болон НББ-ийн журнал бусад холбогдох материал, эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй, горим: Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4000-4200, нийцлийн аудитын гарын авлага, Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмжийг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулан, судалгааны дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу аудитын дараах горимуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймаг, сумын байгаль орчны улсын байцаагч болон сангийн үйл ажиллагааг хариуцсан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, судалгаа хийх,
- Цуглуулсан мэдээ судалгаанд харьцуулалт, нөхцөл байдлын шинжилгээ хийх,
- Сангийн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулгах.

Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн актуудын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглааа. Үүнийг:

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн аудитын тухай хууль,
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль,
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Аудитын хугацаа, агаарын үсэг: Аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 03-ны өдөр хүртэл хугацаанд тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, нийцлийн аудитын багийн ахлах шинжээч Д.Ихбаяр, аудитор Х.Гарам нар гүйцэтгэлээ.

Аудитын дүн:

Аудитаар нийт 98,009.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар холбогдох албан тушаалтнуудад хугацаатай албан шаардлага өгч, зөвлөмжийг тайлангаар хүргүүлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Аймгийн Байгаль хамгаалах сангийн дансыг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон 2015 оны 01 сараас Сангийн сайдын 2015 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 07 тоот тушаалаар БОАЖГ-ын үндсэн дансанд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал болгон өөрчилсөн байна.

Дундговь аймагт 15 суманд байгаль хамгаалах сангийн данстай бөгөөд уг сангийн дансанд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг үндэслэн Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу орлого бүрдүүлж, зарцуулж, тайлагнаж байна.

Сангийн зорилго нь байгалийн төлөв байдлын өөрчлөлтийг судлан тогтоох, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хорт нөлөөллийг багасгах дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаанд иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэн иргэдэд экологийн боловсрол олгох чиглэлээр сангийн хөрөнгийг оновчтой үр ашигтай зарцуулахад оршино.

2015 онд Байгаль хамгаалах сан оны эхэнд 168,413.9 мянган төгрөгийг үлдэгдэлтэй, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон бусад эх үүсвэрээс 356,194.7 мянган төгрөг төвлөрүүлж, гүйцэтгэлээр 294,652.6 мянган төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд зарцуулж, оны эцэст 229,956.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. (Хавсралт №3)

2016 оны эхний хагас жилийн байдлаар оны эхэнд 229,956.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон бусад эх үүсвэрээс 71,520.0 мянган төгрөг төвлөрүүлж, гүйцэтгэлээр 120,786.4 мянган төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд зарцуулж, оны эцэст 180,689.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. (Хавсралт №4)

Бүлэг 1. Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчин бүрдсэн боловч хууль, журмын зарим заалт бодит байдалтай нийцэхгүй байна.

1.1. Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйл, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар аймаг, сумын ИТХ, Засаг дарга байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулахаар заасан байна.

Мөн Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1, 13.4., Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журам”-ын 2.1, 3.1 -д заасны дагуу сангийн орлогыг бүрдүүлж, зарцуулж, тайлагнахаар эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн байна.

1.2. Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй журмын зарим заалт бодит байдалтай нийцэхгүй байна.

ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журам”-ийн 3¹ дугаар заалт, 3.1-3.4 аадыг сэдвээр нь тухайн нөөцөөс орсон орлогыг тухайн төрөлд нь эргүүлэн зарцуулахаар тусгаж өгсөн байна.

Энэ нь ан, амьтны нөөц ашигласны төлбөр, усны нөөц ашигласны төлбөрөөс өөр байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын эх үүсвэргүй говийн бүсэд оршдог манай аймагт хэрэгжихгүй байна.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах ой, ургамлын нөөц судлагдаагүй тус аймгийн хувьд ган зуд тохиох, элсний нүүдэл, цөлжилт ихээр явагддаг онцлогтой учраас ойн зурвас байгуулах, ой мод тарих, төгөл байгуулах, ойн анги нөхөрлөлийг дэмжих ажил Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг² болон “Нэг сая мод ургуулах хөдөлгөөн”³-д өгөгдөж, жил бүр хийгдэж байдаг.

Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын зарим заалттай нийцэхгүй байгаа юм.

Иймд дээрх журмын 3.1-3.4-т тухайн нөөцөөс орсон орлогыг тухайн төрөл, зүйлд нь эргүүлэн зарцуулахаар заасныг бүс нутгийн онцлогт тохируулан тухайн орлогын төрлүүдэд гүйлгэж зарцуулах боломжтой байхаар өөрчлөх шаардлагатай байгаа талаар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайланд Засгийн газарт уламжлуулахаар Үндэсний Аудитын газарт саналаар хүргүүлсэн болно.

¹Орлого, өмчийн хөрөнгийн тухай хууль

² Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” зарлиг

³Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 178 дугаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” зарлигийн хэрэгжилтийг зохион байгуулах зорилгоор Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын “2015 оны А/146 тоот “Нэг сая мод ургуулах хөдөлгөөн”ийг улс орон даяар зохион байгуулах тушаал.

Бүлэг 2. Сангийн хөрөнгийг төлөвлөх, хуульд заасны дагуу бүрэн бүрдүүлэх ажил хангалтгүй байна.

2.1. Сумдын Засаг дарга нар сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөөгүй байна.

Байгаль хамгаалах сангийн орлогын эх үүсвэр нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.1.1.-д /Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж;/, 12.1.2 –т /Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай¹ хуулийн 4.2 дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө./ заасны дагуу бүрдэхээр заасан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1⁴, 13.4⁵, –д байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор санхүүжүүлэх, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлахаар заасан байна.

Мөн ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 2.1-д аймаг нийслэлийн Засаг дарга нь тухай жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1⁶-д заасан хувь хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухай шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар заажээ.

Төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг хүснэгтээр харуулав. Хүснэгт 2.1

Хүснэгт: 2.1

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/
1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь

⁴ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

⁵ Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

⁶ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
3. Газрын нөөцийн төлбөрийн орлого	15 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь

Манай аймгийн хувьд Эрдэнэдалай сумын Засаг даргаас бусад нь “Байгаль хамгаалах сан”-гийн орлого, зардлыг төлөвлөхгүй, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулалгүй зарцуулж байна.

Энэ нь сумдын Засаг дарга, ажил хариуцсан албан тушаалтнуудын хууль эрх зүйн мэдлэг дутмаг, хууль, журмыг хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой бөгөөд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.4⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

2016 оны 9 сард хуралдсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсвийн тодотголоор сумдын байгаль хамгаалах сангийн хөрөнгийн хэмжээг нийт дүнгээр баталсан байна.

Харин сумдын Засаг дарга нар Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.2.⁸-дахь заалтуудыг үндэслэн байгаль хамгаалах сангийн төсвийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж ажиллах шаардлагатай байна.

Харин аймгийн БОАЖГ-ын үндсэн дансаар дамжуулан зарцуулагддаг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд зарцуулах хөрөнгийн хэмжээг төлбөрийн орлогын хувь хэмжээнд үндэслэн төлөвлөсөн боловч, 2015 онд тус зардлыг анх 48,614.0 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотголоор 27,457.0 мянган төгрөг болгон бууруулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөсөн хэмжээг бууруулаагүй байхад байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг тодотгол хийж бууруулсан нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж усны төлбөрөөс орох хувь багасгасантай холбоотой боловч 43.5 хувиар буурсан нь хуульд нийцэхгүй байна.

Аймгийн орон нутгийн төсвөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд хуваарилсан хөрөнгийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцсон эсэхийг давтан тооцоолол хийж, харьцуулахад 2015 онд 9,103.0 мянган төгрөгөөр, 2016 онд 7,840.0 мянган төгрөгөөр тус тус дутуу төлөвлөсөн байна. (Хүснэгт 2.2)

Хүснэгт: 2.2

/2015 он /

Мян.төг

д/д	Орлогын төрөл	2015 оны төлөвлөгөө гүйцэтгэл	2015 оны Хуваарилагдсан зардал	2015 оны Хуулиар байвал зохих	2015 оны зөрүү
-----	---------------	-------------------------------	--------------------------------	-------------------------------	----------------

⁷ Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

⁸ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 2.1-д бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

2	Ус, рашааны НАТО	34,000.0		11,900.0	
4	Газрын төлбөр	164,400.0		24,660.0	
	ДҮН	198,400.0	27,457.0	36,560.0	9,103.0

/2016 он /

Мян.төг

д/д	Орлогын төрөл	2016 оны Орлогын гүйцэтгэл	2016 оны Хуваарилагдсан зардал	2016 оны Хуулиар байвал зохих	2016 оны зөрүү
2	Ус, рашааны НАТО	40,000.0		14,000.0	
4	Газрын төлбөр	180,000.0		27,000.0	
	ДҮН	220,000.0	33,160.0	41,000.0	7,840.0

Энэ нь аймгийн удирдлага, байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтнууд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд хуулийн дагуу хөрөнгө хуваарилж байгаа эсэхэд хяналт тавихгүй байгаатай холбоотой ба Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1⁹, 13.4¹⁰, ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 2.1¹¹-дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Цаашид байгаль орчны асуудал болон төсвийн төлөвлөлт, хяналт хариуцсан албан тушаалтнууд хууль журмаа мөрдөж, хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Аймгийн Засаг дарга, Байгаль орчин аялал жуулчлалын газар нь дараа оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөний саналыг тооцож гаргахдаа сумдын санал болон байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө болон бусад үзүүлэлтийг үндэслэн боловсруулж, Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж байх шаардлагатай байна.

2.2. Сангийн орлогын төлөвлөгөө батлуулаагүйгээс орлогыг хууль, журамд заасны дагуу төрөл тус бүрээр бүрдүүлэх ажилд санаачлагагүй хандсан байна.

2015 онд аймгийн орон нутгийн татварын орлогод байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 233,916.9 мянган төгрөг төвлөрч, орон нутгийн төсвийн орлогоос аймгийн БОАЖГ-ын төсөвт байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд 27,457.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Хүснэгт: 2.3

Аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл

⁹ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

¹⁰ Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

¹¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.


Орлогын төрөл	2014 он		2015 он		2016 он		Нийт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	45,000.0	25,837.0	34,000.0	34,063.3	40,000.0	10,113.0	119,000.0	70,013.3
Амьтны нөөц ашигласны төлбөр		6,400.0		55,200.0			-	61,600.0
Газрын төлбөр	220,000.0	151,068.5	164,400.0	144,653.6	180,000.0	70,013.7	564,400.0	365,735.8
ДҮН	265,000.0	183,305.5	198,400.0	233,916.9	220,000.0	80,126.7	683,400.0	497,349.1

Харин 2016 онд аймгийн орон нутгийн татварын орлогод байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 220,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, БОАЖГ-ын төсөвт байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд 33,160.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 15,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Сумдын байгаль хамгаалах санд 2015 онд 356,194.7 мянга, 2016 онд 71,520.1 мянган төгрөгийн байгалийн нөөц ашигласны төлбөр болон бусад орлого төвлөрсөн байна.

Сумдын байгаль хамгаалах сангийн 2015 оны орлогын гүйцэтгэлийг төрлөөр авч үзвэл нийт орлогын 40.6 хувь буюу 114,524.7 мянган төгрөгийг ан, амьтны нөөц ашигласны төлбөр, 17.9 хувь буюу 63,740.0 мянган төгрөгийг нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн орлого, 14.4 хувь буюу 51,185.0 мянган төгрөгийг хандив тусламжийн орлого тус тус эзэлж байна. (Диаграмм: 2.1, Хавсралт : №1)


Диаграмм 2.1



2016 оны орлогын гүйцэтгэлийг төрлөөр авч үзвэл хуулийн дагуу төвлөрүүлэх төлбөрийн орлогоос мөн л нийт орлогын дийлэнх хувь буюу 23.6 хувь буюу 29,530.0 мянган төгрөгийг ан, амьтны нөөц ашигласны төлбөр эзэлж, 22.4 хувь буюу 27,993.0 мянган төгрөгийг нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн орлого тус тус эзэлж байна. (Диаграмм: 2.2, Хавсралт: №2)

Диаграмм: 2.2

Байгаль хамгаалах сангийн орлогын бүрдүүлэлт 2016 он



- Байгаль орчныг бохирдуулсны болон бусад хортой нөлөөлөл үзүүлсний төлбөрийн орлогын 50 хүртэл хувь;
- Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны нэг удаагийн хураамжийн орлого;
- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого
- Бусад орлого / авлага /Өвс, шатахуун/
- НС-ийн барьцаа хөрөнгө

2015, 2016 онд сумдын байгаль хамгаалах санд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн 29.9 хувийг нь ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлж байна.

2015, 2016 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийг сумдаар авч үзвэл:

№	Сумын нэр	Байгалын нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл				Сумын дүн
		Ангийн нөөц ашигласны төлбөр	Усны төлбөр	Байгаль орчныг бохирдуулсны болон бусад хортой нөлөөлөл үзүүлсний төлбөр	Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны нэг удаагийн хураамж	
1	Äýēäýðöí ãð		774.0	1,687.5	2,100.0	4,561.5
2	Äýðýí	25,600.0				25,600.0
3	Äî äü-óãðààè	10,880.0				10,880.0
4	Öããããí äýēäýð					-
5	Ääýí æàððàèèäí		10,037.5			10,037.5
6	Өндөршил					-
7	Äóðäàí ñàèðàí	65,074.7	10,037.5			75,112.2
8	^a èçèéò			2,090.0		2,090.0
9	Хулд					-
10	Èóóñ		444.0	190.0		634.0
11	Äýēäýððàí ààè					-

12	Нᠠᠡᠳᠠᠢ -ᠢ ᠠᠢ ᠢ					-
13	ᠢᠳᠠᠢ ᠢᠠᠡᠡᠡ		220.0			220.0
14	Адаацаг	64,000.0				64,000.0
15	Сайнцагаан					-
	Дүн	165,554.7	21,513.0	3,967.5	2,100.0	193,135.2

Дээрх байдлаас харахад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос санд орох хувь цөөн хэдэн сумдаас орсон байгаа бөгөөд ихэнх сумд сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх ажилд санаачлагагүй хандаж байна.

Тухайлбал :

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийгдсэн “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар ангийн нөөц ашигласны төлбөрөөс орох хувийг

0°e°äē°ā°ǎé î ðēî âĩ āyāyā ø æðāāāī āāð õóóüā çàññàì õòâü õýí æýýí ýýñ áááááð ÁÕÑ-í ä

0°äē°ð;çëñý ç°ð÷ë;ä èëэрсэн байна. Өбдөөеаае:

- Aī āu-Ōāōāē nōi āi, ài uōi ū í°ō àø èāēānī ū ò°ēá°ðēéí îðēī āī ā 4 òī ēāī é èēyā ø í í ōi ð ø óāóó áāðūñāi ū ò°ēá°ð 25,600.0 ì yī āāi ò°āð° ā îðñī ū ā AŌÑ-í ā 9,500.0 ì yī āā áóþ ó í èéó îðēī āū í 37 ōōāēēā ò°āē° ð¿¿ēæ ōóóēūā çāñāi āī î ā òyī æyú áóþ ó 50 ōōāūā ð¿ðýyā¿é, ¿ēāyāāýē îðēī āī 16,100.0 ì yī āāi ò°āð° āēēā āð° í ðēé îðēī āī ā îðóóēæ 2016 î í ū 07 ñāðā àēi āēéí ÈŌŌ-āāð Í Í ŌÑ-í ā òī āi ðāī ē ðēēēāyæ çāðóóēñāi .
- Nāēí ōāāāāi nōi 2015 î í ā ан, ài uōi ū í°ō àø èāēānī ū ò°ēá°ðēéí îðēī āī ā 1 идлэг ø í í ōi ð ø óāóó áāðūñāi ū ò°ēá°ð 6,400.0 ì yī āāi ò°āð° ā îðñī ū ā тус төлбөрийн орлого ò°ē° āē° ā° ā¿é āyāyā ø àēðāāi āāð AŌÑ-í ā î āð ò° āē° ð¿¿ēyūā¿é, ð¿āyūi yē òāððāòðāē àø èāð ì àēòì àēū í í°ō àø èāēānī ū ò°ēá°ðò 100 ōóāū ò° āē° ð¿¿ēæ òāēēāāi āñāi .

Үй үй бүл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1¹², ҮА-ий 2013-ий 03-адаахд ньдүй 16-ий "адаеи 93-адаахд ой аойи еүй 2-адаахд хавсралтаар батлагдсан "Ховор амьтан агнах, барих, тусгай зөвшөөрөл олгох" журмын 6.5.¹³, 6.6¹⁴-дахь сәәәдәбәәү ә дөн дөн с° д÷н° ааеи а.

Мөн сумдын Засаг дарга нар хуульд заасан дараах нэр төрлийн орлогыг огт төвлөрүүлээгүй, орлого нэмэгдүүлэх талаар санаачлагагүй хандаж Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.1¹⁵-дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж,
- Ус бохирдүүлсны орлого,

¹² Энэ хуулийн 13.2-г заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

¹³ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу тусгай зориулалтаар агнаж, барьсан ан амьтны төлбөрийн орлогын 50-иас доошгүй хувийг агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна.

14 Агнуурын бүс нутагт тусгай зөвшөөрлөөр агнаж, барьсан ан амьтны төлбөрийн 50-иас доошгүй хувийг зөвхөн тухайн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна.

¹⁵ Байгаль хамгаалах сангийн хөрөнгө энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого,
- Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлого.

Энэ нь сангийн орлогыг хуульд заасан нэр төрлөөр нь болон байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тухайн жилд байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх төлөвлөгөө, чиглэлтэйгээ уялдуулан төлөвлөдөггүйгээс шалтгаалж байна.

Цаашид аймаг сумдын Засаг дарга, байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд сангийн орлогыг хууль, журамд заасан төрөл тус бүрээр бүрдүүлэх тал дээр санаачлагатай ажиллах шаардлагатай байна.

Бүлэг 3. Сангийн хөрөнгийг зөвхөн сумын Засаг даргын шийдвэрээр хяналтгүй зарцуулж байна.

3.1 Зарим сумдын Засаг дарга нар сангийн хөрөнгийг урсгалаар, зориулалтын бус зардалд зарцуулж байна.

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх болон бусад зардалд гүйцэтгэлээр 2015 онд 294,652.6 мянган төгрөг, 2016 оны хувьд эхний хагас жилийн байдлаар 120,786.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. (Хавсралт № 3, 4)

Аймгийн БОАЖГ-ын төсөвт орон нутгийн төсвөөс байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд хуваарилсан хөрөнгийг 2014-2016 оноор харьцуулахад 2014 оноос буурсан байгаа бөгөөд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл тухайн жилүүдэд буураагүй байхад бууруулж баталсан нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж усны төлбөрөөс орох хувь багасгасантай холбоотой боловч хуульд нийцэхгүй байна. (Хүснэгт 3.1)

Хүснэгт: 3.1

	2014		2015		2016	
Байгаль нөхөн сэргээх зардал	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
	69,700.0	69,700.0	27,457.0	27456.4	33,160.0	14,350.0

Мөн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажилд зарцуулж байгаа дээрх хөрөнгө нь дэндүү бага, хүрэлцээ муу байгаа юм. Тухайлбал:

2015 онд авсан санхүүжилтээс 20,000.0 мянган төгрөгийг аймгийн төв дээр ойжуулалтын ажил хийж, 5,000.0 мянган төгрөгийг 2 сум /Баянжаргалан, Өндөршил/ -ын булгийн эх хаших, үлдсэн хөрөнгийг сургалт сурталчилгаа тараах материалын зардалд зарцуулсан байна.

2015 онд Аймгийн БОАЖГ орон нутгийн төсвөөс байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд 27,457.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 27,456,4 мянган төгрөгийг зарцуулж 0.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг дараах байдлаар төлөвлөж бүрэн гүйцэтгэжээ. /Хүснэгт 3.2/

Хүснэгт: 3.2

№	Зардал (Хэрэгжүүлэх арг хэмжээ)	Хэмжих нэгж	Тоо	ИТХ-ын хурлаар батлагдсан төсөв /мян.төг/	Байгаль орчин ногоо хөгжил, аялал жуулчлалын сайд, Дундговь аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээгээр	Гүйцэтгэл /мян.төг/
---	------------------------------------	----------------	-----	---	---	------------------------

1	Ойн зурвас байгуулах 10 га	Га	10	20,000.0	20,000.0	20,000.0
2	Булаг шандын эхийг хаших	ш	2	5,000.0	5,000.0	5,000.0
3	Аймагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллага /Телевиз, сонин, сэтгүүл, радио, цахим сүлжээ гм /-уудтай хамтран байгаль орчин адал жуулчлалын салбарын хуулт тогтоомжийг улирлын онцлогтой уялдуулан мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийж олон нийтийн байгаль орчноо хамгаалах уламжлалт дадлыг сэргээх	ком	1	2,457.0	2,457.0	2,456.4
	Дүн			27,457.0	27,457.0	27,456.4

Цаашид орон нутгийн төсвөөс байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд олгох санхүүжилтийг нэмэгдүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнтэй, хүртээмжтэй болгох нь зүйтэй байна.

Харин сумдын хувьд хууль, журмын дагуу орлогын эх үүсвэрээ бүрдүүлж, зарцуулж байгаа бөгөөд 2015 онд нийт 294,652.6 мянган төгрөгийн зардал гаргаж 24 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Үүнээс дараах арга хэмжээнд зарцуулсан зардлууд дийлэнхи хувийг эзэлж байна. Үүнд:

